



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.07 №49 (49)

ЦАХИМ ШУУДАНД

БАЙЛДАГЧ НАР ААВ БОЛСОН ОНЖАВЫНХАА БАЯРЫГ ХУВААЛЦАВ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Тус ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч О.Ариунбаатар аав болсон тухай баяртай мэдээ ангийн холбоогоор дамжуулан ирэв. Байлдагчийн баярыг онжавууд хамтдаа хуваалцаж, баяр хүргэсэн юм. Түүнтэй ярилцнаа хүргэе.

Эрхэм байлдагч өөрийгөө танилцуулахгүй юу?

-Би Сүхбаатар аймгийн Онгон суманд 2000 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр төрсөн. 2020 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн алба хаахаар ирсэн жирийн нэгэн залуу.

Өнөөдөр гэхдээ таныг жирийн нэгэн залуу гэж тодорхойлохгүй, эх орны эр цэрэг гэж нэрлэмээр байна...

-Тийм ээ, баярлалаа. Аав ээж маань “Дараа жил цэрэгт яваарай” гэхэд нь зөрсөөр байгаад ирсэн. Ирсэн нь ч оносон. Сайхан хамт олны дунд ихийг сурч, өөрийгөө нээж, зоригжуулж, нутаг нутгаас ирсэн олон аавын хүүтэй харилцаж сурлаа.

Амьдралд хэрэгцээтэй олон чанарыг цэргийн албанаас сурч байна даа.

Таны дуулж байгаа бичлэг хэд хоногийн өмнө олон нийтийн сүлжээгээр цацагдсан. Та их сайхан дуулдаг юм байна.

-Баярлалаа. Багаасаа морь малдаа явахдаа л дуулж өссөн. Морин дэл дээр адуугаа хураагаад сайхан дуулаад, исгэрээд явах чинь эр хүний бас нэг хийморь шүү дээ. Тэр өдөр би ротын ээлжтэнээр гарч байсан юм, тэгсэн ахлах дэслэгч Б.Мөнх-Эрдэнэ бичлэг хийгээд цацсан юм билээ. Хүмүүс “Ямар сайхан дуулдаг байлдагч вэ” гээд сэтгэгдэл үлдээснийг нь хараад баярласан шүү.

Бас нэг баярт мэдээ нь та аав болсон?

-Тэгэлгүй яах вэ. Эхнэрийг маань А.Сугаргарав гэдэг. Бид Сүхбаатар аймагт танилцаж, хоёр биедээ дасаж, гэр бүл болсон. Охинтой болсондоо үнэхээр их баяртай байна. Аав хүний хариуцлагыг улам их мэдэрч, хугацаат цэргийн алба нэр төртэй хаагаад эхнэр, охин хоёртоо очно оо.

Ахмад Д.ГАНБААТАР

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД БИЕ БИЕЭСЭЭ СУРАЛЦСААР...



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Тус ангиас хугацаат цэргийн алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрсдийгөө бие даан хөгжихөд нь туслах зорилгоор англи хэл, уран зураг, гитарын дугуйланг тус тус хичээллүүлж байгаа билээ.


Тэгвэл хугацаат албаны дайчдын санаачилгаар монгол бичиг, сойлогос хэл, шатар, 100 буудалт даамны дугуйланг нэмэлтээр хичээллүүлж эхлээд байна. Монгол бичгийн багш, байлдагч А.Төгөлдөр МУБИС-ийг монгол хэл, уран зохиолын багш мэргэжлээр дүүргэж, нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар дунд сургуульд мэргэжлээрээ ажиллаж

байгаад хугацаат цэргийн албанд татагдан ирсэн юм. Тэрээр дугуйлангаа удирдахын зэрэгцээ бичиг үсэг үл мэдэгч хугацаат цэргийн гурван алба хаагчид хичээл зааж байгаа юм.

Түүнчлэн илтгэх ур чадварыг нь сайжруулах, өөртөө итгэлтэй иргэн болж төлөвшихөд нь туслах зорилгоор долоо хоног бүр хугацаат цэргийн алба хаагчдыг өөрсдийнх нь сонирхсон сэдвээр илтгэл хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Тухайлбал, энэ долоо хоногт байлдагч Ө.Дөлгөөн “Ус чандмань эрдэнэ”, байлдагч М.Доржсамбуу “Эх орны хөгжил бидний гарт”, байлдагч А.Энхжин “Авто машин” сэдвээр сонирхолтой илтгэлийг хэлэлцүүлээ.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

ЦАХИМ НОМЫН САНГ АЖИЛЛУУЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Тус анги цахим номын санг ажиллуулж офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч, ажилтан албан хаагчдад үйлчилж байна. Цахим номын сангаар дамжуулан сэтгэл зүйн бэлтгэл, ёс суртахуун, хууль, эрх зүйн мэдлэг олгох мэдээллийн багцыг бие бүрэлдэхүүнд судлуулж байгаа юм. Мөн хугацаат цэргийн алба хаагчдын дунд нүүдлийн номын санг ажиллуулж, уншсан номоо нэгэндээ ярьж хуваалцах санаачилгыг өрнүүлээ.

Түүнчлэн бие бүрэлдэхүүний ёс суртахуун, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Цэргийн нийтлэг дүрэм, ёс зүйн дүрмээр “Өврийн дэвтэр” гаргаж, офицер, ахлагч нарт тараав.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
11	-3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
28	22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
22	12

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.405.00	3.465.00
CNY	438.50	441.90
RUB	37.60	39.20
JPY	25.82	26.32
KRW	2.44	2.58

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 26
2021.05.07.
/БААСАН ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН ДОЛООН УЛААН ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Жаргал үргэлжид ирнэ.

Наран ургах, шингэх:
05.25-20.13

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал:

Хий.

Арьин тооллын 5 дугаар сарын 7, Сувар гараг. Билгийн тооллын 26, Могойг хүлээч одтой, хөхөгчин туулай өдөр. Өдрийн наран 5 цаг 25 минутад мандан, 20 цаг 13 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, гаргийг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одоосод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

42.464

ЭДГЭРСЭН

27.242

НАС БАРСАН

142/11

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2120 (26)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

309

ЭДГЭРСЭН

1785

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 153,954,491

Эдгэрсэн

Нийт: 127,309,964

Нас барсан

Нийт: 3,221,052

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН	НИЙТ
Сүүлийн 24 цагт	118,500
НИЙТ	1,756,434
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/	НИЙТ
Сүүлийн 24 цагт	9,253
НИЙТ	2,754,347
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО	НИЙТ
Сүүлийн 24 цагт	1,968
НИЙТ	386,585
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН	НИЙТ
Сүүлийн 24 цагт	458
НИЙТ	70,752

2021.05.06 11:00 ЦАХИМ БАЙДЛАМ



СПОРТ

Э.БЭХБАЯР ЭХНИЙ
ЯЛАЛТАА АВЛАА

"Токио-2020" зуны олимпийн эрх олгох дэлхийн тэмцээн өчигдөр Болгар улсын Софи хотноо эхэллээ. Олимпийн эрх олгох энэхүү сүүлийн тэмцээнд Монгол Улсаас таван тамирчин, гурван дасгалжуулагчийн хамт оролцохоор Казахстан Улсад бэлтгэлээ хангасан юм. Тэмцээний салхийг хагалж 97 кг-ын жинд ОУХМ Ч.Алтангэрэл эхний тойрогтоо БНСУ-ын Сиво Минвоныг торгуулиар цэвэр яллаа. Өмнөд Солонгосын бөх барилдааны үеэр спортын бус авир гаргаж, манай

бөхийг жийж торгуулиар хөөгдсөн юм.

Түүнчлэн 57 кг-ын жинд эхний тойрогтоо гоц мөргөсөн МУГТ Э.Бэхбаяр Украины Тарас Марковичийг яллаа. Түүний хувьд шөвгийн наймд Италийн тамирчин Гиви Давидовитай барилдах юм. Харин эхний тойрогт 74 кг-ын жинд Б.Бямбадорж Украины Василий Михаиловтой барилдаж ялагдсан бол 86 кг-ын жинд МУГТ П.Өнөрбат Германы Ахмед Дударовт ялагдснаар олимпийн эрхгүй хоцорлоо.

НИЙГЭМ

50 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ИРГЭДИЙН
ДАНСАНД ШИЛЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

Засгийн газрын энэ сарын 5-ны өдрийн ээлжит хуралдаанаар вакцины хоёр тунгаа хийлгэсэн иргэн бүрд 50 мянган төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн.

Тэгвэл уг мөнгийг иргэдийн дансанд өчигдрөөс шилжүүлж эхэллээ. Энэхүү ажлыг ЭМЯ, Сангийн яамтай хамтран хэрэгжүүлж байгаа юм. Халамж авдаг 90 мянга, мөн хүнсний талон авдаг 30 мянган иргэн вакцинд хамрагдаагүй байгаа тухай судалгаа гарсан байна. Тиймээс иргэдийг нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, вакцинжуулалтад идэвхтэй хамрагдахыг Засгийн газраас уриалж байна.

5 ДУГААР САРЫН 8-НААС
СУРАГЧДЫН ЗУНЫ АМРАЛТ
ЭХЭЛНЭ

Боловсрол, шинжлэх ухааны яам хичээлийн жилийн бүтцэд өөрчлөлт оруулах асуудлаар цахим хурал зохион байгуулав.

Сурагчдын хичээллэх, амрах хугацааг зохицуулах эрх БШУ-ны сайдад байдаг. Энэ эрхийнхээ хүрээнд сурагчдын амрах хугацааг наашлуулах шийдвэр гаргалаа.

Цар тахлын улмаас сурагчид 2019-2020 оны хичээлийн жилд буюу ноднин үзэх ёстой нийт хичээлийнхээ 45 орчим хувийг зайнаас судалсан байдаг. Харин энэ хичээлийн жилд 60-68 хувийг теле болон цахим байдлаар хичээллэсэн байна. Энэ хичээлийн жилд цэцэрлэгт 247040 хүүхэд, ЕБС-д 680837 хүүхэд суралцаж байна. Зайн сургалт урт хугацаагаар үргэлжлэх нь сурагчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, ялгаатай байдлыг нэмэгдүүлэх, багш сургуулийн өдрийн ачааллыг нэмэгдүүлэх зэрэг олон сөрөг үр дагавартай байгаа учир амралтыг наашлуулахаар хэд хэдэн хувилбар боловсруулсан.

Боловсруулсан саналуудынхаа хүрээнд эцэг эх, асран хамгаалагчид, багш, сургуулийн удирдлагуудын дунд санал асуулга явуулахад багш нарын 72 хувь, эцэг эхчүүдийн 70 хувь нь амралтыг наашлуулах болоод намар эрт хичээллэж эхлэх саналыг дэмжсэн байна. Мөн мэргэжлийн байгууллагууд болон ажил хариуцагчидтай зөвлөсөн болно.

Ингээд 1-3 дугаар ангийн сурагчдыг 2021.05.07-ны өдөр хичээллүүлээд амрах бол 4-12 дугаар ангийн сурагчид 2021.05.14-ний баасан гарагт хичээллээд амарна. 9 дүгээр анги төгсөөд МСҮТ-д элсэх хүсэлтэй сурагчид хичээлийн агуулгаа үргэлжлүүлэн теле байдлаар судлах боломжтой. Харин 12 дугаар ангийн сурагчид 14-ний өдрөөс эхлэн давтлагад хамрагдана. Багш нарын амралтыг 6 сарын 1-нд эхлүүлэхээр төлөвлөж байна.

Амралт эхлэх шийдвэртэй холбоотойгоор улсын болон анги дэвших шалгалтыг өнгөрсөн жилийн нэгэн адилаар цуцалж байна. Гэхдээ шалгалт авахгүй ч дун гаргана. Дүнг гаргахдаа танхимаар хичээллэсэн хугацааны амжилт, зайнаас хичээллэсэн үеийн идэвх, бусад оролцоо зэргийг харгалзаж үзэх юм. Дүн гаргах аргачлалыг сургууль, багш нарт хүргэж байна.

Элсэлтийн өрөнхий шалгалтын зохион байгуулалттай холбоотой мэдээллийг ирэх 7 хоногт зарлана. Эрт намар байгаа учир намар наймдугаар сарын 15-ны өдрөөс хичээлийг эхлүүлэх ажлыг одооноос зохион байгуулна. Амралтын хугацаанд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдийнхээ дархлааг дэмжих, сэтгэл санааг сэргээх зэргээр анхаарал хандуулахыг хүсье.

Эх сурвалж: БШУЯ

ГАДААДЫН ЦЭРГИЙН МЭДЭЭ

ЯЛАЛТЫН
ЁСЛОЛЫН
ЖАГСААЛД
12 МЯНГАН
ЦЭРЭГ, 190
БАЙЛДААНЫ
ТЕХНИК
ОРОЛЦОНО

Удахгүй тохиох Аугаа их Эх орны дайны ялалтын 76 жилийн ойн ёслолын үеэр Улаан талбай дээгүүр нисэх байлдааны онгоц, нисдэг тэрэгнүүдийн ёслолын жагсаалын нэгдсэн бэлтгэл өнгөрсөн Лхагва гарагт боллоо.

Эх орны дайны ялалтын ойд зориулж энэ удаа 23 нисдэг тэрэг, 53 онгоц буюу нийт 76 онгоц, нисдэг тэрэг нисэх юм. Түүхэндээ анх удаа гурван нэгж ачаа-тээврийн "Ми-26" нисдэг тэрэгнээс гадна тээврийн "Ми-8", дайрагч "Ми-35", "Ка-52"-ийн бүлэг нисдэг тэрэг, шоу үзүүлбэрийн "Алтан бүргэд" нисдэг тэрэгний баг тус тус оролцохоор болжээ. Нисэх онгоцны хувьд "Ту-160" стратегийн бөмбөгдөгч хамгийн урд нисэх бөгөөд түүнийг олон зориулалт бүхий дайрагч "Су-35С" онгоц хамгаалж ниснэ. Мөн стратегийн бөмбөгдөгч "Ту-160М", "Ту-95МС",

шатахуун тээвэрлэгч "Ил-78", "Ил-76" онгоцыг "Су-35С", "Су-34", "Су-24М" онгоц хамгаалан нисэхээр бэлтгэлээ хангажээ.

Ёслолын парад "МиГ-31К", "Су-57" сөнөөгч онгоц ниссэнээр өндөрлөнө. Түүний дараа болох агаарын шоу үзүүлбэрийн хүрээнд "Кубинка даймонд", "Русские Витязи", "Стрижи" нислэгийн баг "МиГ-29", "Су-25" сөнөөгч онгоцоор ОХУ-ын төрийн далбааны өнгөөр тэнгэрт утаа хаях ажээ. Тус улсын Батлан хамгаалах яамны мэдээлснээр нисэх онгоц, нисдэг тэргүүд Улаан талбай дээгүүр 180-550 метрийн өндөрт 200-500 км/ц-ийн хурдтай нисэх гэнэ. Нацист Германы түрэмгийллийг дарсан Аугаа их Эх орны дайны 76 дахь удаагийн ялалтын парадд 12 мянган цэрэг, 190 байлдааны техник оролцохоор бэлтгэлээ хангаж байгаа аж.

ШИНЭ ЗЭВСЭГ, ТЕХНИК

"САРМАТ"-ЫН ЗЭВСЭТЛЭЛД
АВАХАД ТУН ОЙРТЛСОН

ОХУ энэ жил "Сармат" тив алгасан нисэх баллистик пуужингийн гурван нэгж цогцолборыг хүлээн авахаар зэхэж байна гэж тус улсын Батлан хамгаалахын сайд С.Шойгу өнгөрсөн долоо хоногт сэтгүүлчидтэй хийсэн уулзалтын үеэр хэлсэн юм.

Тэрээр мөн энэ оны гуравдугаар улирал гэхэд "Сармат" пуужингийн цогцолборын сүүлийн шатны туршилтыг хийж дуусгана хэмээн мэдэгджээ. Өөр нэгэн эх сурвалжийн мэдээлж байгаагаар пуужингийн нэгдүгээр цогцолборын бүх туршилт аль хэдийнэ Камчаткын "Кура" төстийн полигонд явагдаж дууссан байна. "РиаНовости" агентлагийн мэдээлснээр ОХУ-ын Баруун хойд хязгаарт байрлах сансрын тээвэрлэгч пуужингийн "Плесецк" үйлдвэрт тус пуужингийн цогцолборыг үйлдвэрлэж байгаа

ажээ. Пуужингийн гурван нэгж цогцолборыг ирэх оны эхний улиралд багтаан зэвсэглэлд авах төлөвлөгөөтэй байгаа юм.

"Сармат" нь 1970 он буюу ЗХУ-ын үеэс ашиглаж ирсэн "Р-36М2 Воевода" пуужингийн цогцолборыг үндсэнд нь "тэтгэвэрт" гаргаж байгаа хэрэг юм. Тус пуужин нь бүх талаараа "Воевода"-аас давуу, дэвшилтэт технологид суурилсан байдлаар бүтээгдэж байна.

"Сармат"-ын жин нь 208.1 тонн бөгөөд 10 тонн бүхий цэнэг тээж, 178 тонн хатуу түлш өөртөө агуулах боломжтой. Одоогийн байдлаар нислэгийн алслалтыг 18 мянга эсвэл түүнээс дээш километр гэж тооцоолж байна. Пуужин зэвсэглэлд шилжсэнээр ОХУ-ын Батлан хамгаалах чадавхыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлнэ гэж

цэргийн шинжээчид үзжээ. "Сармат"-ын хурдасгуурын технологи маш сайн тул нислэгийн үед түүнийг устгахад тун хүндрэлтэй аж. Өөрөөр хэлбэл, пуужинд байрласан богино хурдасгуурууд нь "маневрлах чадварыг нэмэгдүүлсэн байна. Гол хөдөлгөөр нь пуужинг богино хугацаанд өндөр хурд авах боломж олгохоос гадна үндсэн нислэгийнхээ явцад нислэгийн хурдаа ямар ч байдлаар өөрчлөх техникийн шийдэлтэйгээр үйлдвэрлэгдэж байгаа аж.

Уг пуужин нь дэлхийн аль ч өнцөг булан бүрд хүрч чадах бөгөөд Хойд, Өмнөд туйлын дээгүүр ч нисэх найдвартай ажиллагаатай. Мөн өөртөө дуунаас хэт хурдан "Авангард" пуужинг агуулж, үндсэн нислэгийн маршрут хүртэл тээвэрлэх боломжтой юм байна.